

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА / албан тушаалын нэр / А.ӨНӨРЖАРГАЛ / нэр / -ний
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		
		Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт
1	2	3	4	5
НЭГ. "Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дэмжлэг үзүүлэх ажлыг хэрэгжилтийг хангах, арга зүйн зохион байгуулах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД / Албан тушаалын зорилго, зорилтод суурилсан ТЖАХ-ийн гүйцэтгэлийн зорилт /				
1	Арга хэмжээ №1.1. Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, харьяалах байгууллагад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх	Дэмжлэг үзүүлсэн тоо	15	Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмууд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор нутгийн захиргааны 24 төрийн байгууллага бүрт хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн биелэлтийг хангах, нийгмийн хамгааллын хөтөлбөрийг боловсруулах, сургалтын хөтөлбөр боловсруулах, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийг төлөвлөгөөг боловсруулахад хэрэгжүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагааны чиглэлээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудаас Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, нөөцийн санг ашиглах журмын төсөл, Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журмын төсөл, Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журмын төсөл, Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн хүргүүлсэн. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%

2	Арга хэмжээ №1.2. Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан заавар, аргачлалын хүрээнд зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх	Дэмжлэг үзүүлсэн тоо	3	Аймгийн Засаг даргын Тамгын газрын улсын байцаагч нар, Биеийн тамир спортын газрын дарга, соёл урлагийн чиглэлийн төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга, улсын байцаагч нар нийт 17 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахтай холбоотой тухайн төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан заавар, аргачлалын хүрээнд зохион байгуулах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч, боловсруулан Орхон аймаг дахь Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлж батлах зөвшөөрөл авч тухайн төсвийн шууд захирагч нар албан тушаалын тодорхойлолтуудыг батлан мөрдөж байна.. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
3	Арга хэмжээ 1.3 Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлж буй эсэхэд хяналт тавих	тоо	4	Аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс албадын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт, үнэлгээ хийх Ажлын хэсэгт ажиллан нутгийн захиргааны 24 төрийн байгууллагын 449 төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолт мөрдүүлж байгаа эсэхэд хяналт тавин ажилласан. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
ХОЁР. "Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, шалгалтын дүнг тайлагнах, Төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх, төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг зохион байгуулах, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн чиглэлээр зохион байгуулах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД / Албан тушаалын зорилго, зорилтод суурилсан ТЖАХ-ийн гүйцэтгэлийн зорилт /				
4	Арга хэмжээ №2.1. Тусгай шалгалтын сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах, шалгалтын комисс бүрдүүлэх, тусгай шалгалтыг зохион байгуулах, шалгалтын дүнг тайлагнах	зохион байгуулсан тоо	Гүйцэтгэлээр	2024 онд төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг 43 байгууллагын /давхардсан тоогоор/ 79 сул албан тушаалын захиалгыг хүлээн авч, холбогдох хууль, эрх зүйт нийцэж байгаад үнэлгээ хийн, төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах зарыг нийтэд мэдээлсэнээс төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа 10 төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэн томилсон. Шилжүүлэх зараар нөхөгдөөгүй 70 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд 13 удаа хүргүүлсэн бөгөөд туслах түшмэлийн -

2, дэс түшмэлийн 10, ахлах түшмэлийн -4 удаа, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч-3 нийт 19 удаа Салбар зөвлөлийн тогтоолоор байгуулагдсан комисс тусгай шалгалтыг зохион байгуулахад 53 буюу 75.7 хувь нөхөгдсөн бөгөөд Төрийн албаны салбар зөвлөлөөс тэнцсэн оролцогч нарыг нэр дэвшүүлэн тухайн байгууллагуудад томилсон бөгөөд тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.

Эдгээр тусгай шалгалтаар тэнцсэн иргэдийн 21 нь төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэд байна.

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Усан хангамж, ариутгах татуургын хяналтын улсын байцаагч, Хотын захирагчийн албаны Инженерийн байгууламж, шугам сүжээний асуудал хариуцсан мэргэжилтэн, Төсөвчин, Эрүүл мэндийн газрын Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт, осол гэмтлын тандалт хариуцсан мэргэжилтэн, Эх барих эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Яаралтай, гамшгийг үеийн тусламж үйлчилгээ, оношилгоо эмчилгээний технологи хариуцсан мэргэжилтэн, Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдлын вирусын өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн Амьсгалын зам, сүрьеэгийн халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн, Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал, амны хөндийн эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн, Боловсрол шинжлэх ухааны газрын Дизайн техник, дүрслэх урлаг судлал хариуцсан мэргэжилтэн, Математик, мэдээллийн технологийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч Биеийн тамир судлагдахуун хариуцсан мэргэжилтэн, Соёл, урлагийн газрын Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Мал эмнэлгийн газрын Жаргалант сумын Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйчийн сул орон тоог тухайн жил 2-3 удаа нийтэд зарласан бөгөөд оролцогч материалаа илгээгүй тул тухайн албан тушаалууд нөхөгдөөгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу 22 удаа 40 байгууллагын 61 албан тушаалд шилжих зарыг нийтэд зарласнаас төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа 10 төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэн томилсон.

Тусгай шалгалтуудын бүртгэл, зохион байгуулалтай холбоотой гомдол санал гараагүй бөгөөд тайланг хуулийн хугацаанд Төрийн албаны зөвлөлд тухай бүр нь хүргүүлсэн.

				Төрийн албаны зөвлөлийн цахим хаягт тусгай шалгалтын зар тавигдсаны дараа орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам, цахимаар бүртгүүлэх зөвлөмжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч аймгийн ЗДТГ-ын цахим хуудас болон мэдээллийн самбар, тухайн байгууллагын цахим хуудасанд байршуулж нийтэд мэдээлж хэвшсэн. Шалгалтын үйл явцыг камераар баримтжуулж, сонирхсон этгээд шалгалтын үйл явцыг дэлгэцээр ажиглан харах, түүнчлэн шалгалтын үйл явцыг Төрийн албаны зөвлөлөөс хянах боломжийг ханган ажилласан. 2024.01.01.-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
5	Арга хэмжээ №2.2. Албан тушаалын сул орон тоонд зохих журмын дагуу нэр дэвшүүлэх, нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, удирдлагыг мэдээллээр хангах	Хэрэгжилтийн хувь	Гүйцэтгэлээр	2024 онд төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг 43 байгууллагын /давхардсан тоогоор/ 79 сул албан тушаалын захиалгыг хүлээн авч, холбогдох хууль, эрх зүйт нийцэж байгаад үнэлгээ хийн, төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах зарыг нийтэд мэдээлсэнээс төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа 10 төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэн томилсон. Шилжүүлэх зараар нөхөгдөөгүй 70 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд 13 удаа хүргүүлсэн бөгөөд туслах түшмэлийн - 2, дэс түшмэлийн 10, ахлах түшмэлийн -4 удаа, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч-3 нийт 19 удаа Салбар зөвлөлийн тогтоолоор байгуулагдсан комисс тусгай шалгалтыг зохион байгуулахад 53 буюу 75.7 хувь нөхөгдсөн бөгөөд Төрийн албаны салбар зөвлөлөөс тэнцсэн оролцогч нарыг нэр дэвшүүлэн тухайн байгууллагуудад томилсон бөгөөд тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
6	Арга хэмжээ №2.3 . Ерөнхий шалгалтыг нутаг дэвсгэрийн хүрээнд улирал бүр зохион байгуулах	Шалгалт зохион байгуулсан тоо	4	Төрийн албаны зөвлөлийн цахим хаягт Ерөнхий шалгалтын зар тавигдсаны дараа орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журмын дэлгэрэнгүй мэдээлэл өгч, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж нийтэд мэдээлж хэвшсэн. Мөн шалгалтын товыг аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас www.erdenet.mn сайтад болон мэдээллийн самбарт байршуулж нийтэд мэдээлсэн. Ерөнхий шалгалтад бүртгүүлэх иргэдэд цахим бүртгэлд бүртгүүлэх талаар зөвлөмж бэлтгэн аймгийн Засаг даргын Тамгын

			газрын цахим хуудас www.erdenet.mn сайтад болон мэдээллийн самбарт байршуулж нийтэд мэдээлсэн. Төрийн албаны цахим бүртгэлтэй холбоотой 68 хүсэлтийг утсаар болон биеэр хүлээн авч тухай бүр зөвлөмж өгч бүртгүүлсэн. Салбар зөвлөлөөс ерөнхий шалгалтад бүртгүүлэх зөвлөмжийг иргэдэд түгээсэн. Орхон аймаг дахь ТА3СЗ-ийн албан бичгээр Ерөнхий шалгалт зохион байгуулах үед хамтран ажиллах талаар аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Тагнуулийн Ерөнхий газрын харъяа Орхон аймаг дахь Тагнуулийн газар, Цахилгаан дамжуулах Үндэсний төв, Онцгой байдлын газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, “Эрдэнэт-Ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-д мэдэгдэн хамтран ажилласан. 2024 онд ерөнхий шалгалт 4 удаа зохион байгуулахад 421 иргэн шалгалтад оролцохоор бүртгүүлсэнээс 344 иргэн буюу 81.7 хувь нь шалгалтад оролцон 134 иргэн буюу 38.9 хувь нь тэнцэж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн. Шалгалт өгч байгаа иргэд Ерөнхий мэдлэгийн шалгалтад 2024 оны 1 улиралд 40.7 хувь нь тэнцэж байсан бол 2 дугаар улиралд 59.2 хувь, 3 дугаар улиралд 45.48 хувь, 4 улиралд 52.7 хувь, монгол хэл бичгийн шалгалтад 2024 оны 1 улиралд 38.3 хувь нь тэнцэж байсан бол 2 дугаар улиралд 53.9 хувь, 3 дугаар улиралд 43.28 хувь, 4 улиралд 49.6 хувь, дүн шинжилгээ хийх чадварын шалгалт 2024 оны 1 улиралд 16.0 хувь нь тэнцэж байсан бол 2 дугаар улиралд 50.0 хувь, 3 дугаар улиралд 38.28 , 4 улиралд 48.33 хувь хувь нь тус тус тэнцсэн байна. Ерөнхий шалгалт зохион байгуулах бэлтгэл Ажлын хүрээнд ерөнхий шалгалтад бүртгүүлсэн иргэдэд “Бат гэгээн эрдэм” ТББ -тай хамтран 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Тухайн сургалтад хамрагдсан иргэдийн хүсэлтээр 06:00-22:00 цаг хүртэл сургалтыг хийсэн. ТАСЗ-өөс тухайн сургалтыг зохион байгуулах байраар хангаж өгсөн бөгөөд тухайн сургалтад хамрагдсан 25 иргэн 92 хувь ерөнхий шалгалтандаа тэнцсэн. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
ГУРАВ. “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛӨӨС БАТАЛСАН ЗААВАР, АРГАЧЛАЛЫН ХҮРЭЭНД ХҮНИЙ НӨӨЦИЙН АУДИТ ХИЙХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД			
7	Үнэлгээ хийсэн тоо		Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд орон нутагт ажилласан бөгөөд Ёс зүйн

	Арга хэмжээ 3.1.Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд Төрийн албаны зөвлөлөөс баталсан удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, үр дүнг мэдээлэх		2	хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгсөөр ахлуулсан ажлын хэсэг Орхон аймагт ажилласан.. Ажлын хэсэг Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль болон Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт” сургалт, мэдээлэл төрийн албан хаагчид, Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд хийх, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 332 дугаар тогтоолын хэрэгжилттэй танилцах, 2021 оны 10-р сараас хойших хугацааны төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаа, хүний нөөцийн удирдлагын шийдвэрт хяналт шалгалт хийж, зөвлөн туслах 2024 оны 05 дугаар сарын 2-ны өдрөөс 04-ны өдөр хүртэл ажилласан. Төрийн албаны зөвлөлөөс баталсан удирдамжийн дагуу захиргааны 24 байгууллагын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 332 дугаар тогтоолын хэрэгжилттэй танилцах, 2021 оны 10 дугаар сараас хойшхи хугацааны төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаа, хүний нөөцийн удирдлагын шийдвэрт хяналт шалгалт хийж, зөвлөн туслан өнгөрсөн оны хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгасан байдалтай газар дээр нь танилцсан. Өнгөрсөн онд хүний нөөцийн чиглэлээр 16 зөрчил илэрсэнг 100 арилгуулсан бөгөөд энэ удаагийн шалгалтаар төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаа, хүний нөөцийн удирдлагын шийдвэрт ноцтой зөрчил илрээгүй болно. Ажлын хэсгээс хяналт шалгалтын дүнг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
8	Арга хэмжээ 3.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцон ажиллах	Хэрэгжилтийн хувь	65.0	Төрийн байгууллага бүр албан хаагчдыг дэмжих нийгмийн хамгааллын болон сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хөтөлбөрийн дагуу судалгааг хагас бүтэн жилээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна. 2024 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран “Баг/хорооны засаг дарга нарыг чадавхжуулах нь” богино хугацааны сургалтад Сургагч багш бэлтгэх сургалтад 2 байгууллагын 3, нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 5 байгууллагын 5, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 12 байгууллагын 12, дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 16 байгууллагын 17 төрийн албан хаагч, цаашид ажиллах

				ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 8 байгууллагын 11 төрийн албан хаагч, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 1 байгууллагын 1 албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх орон нутгийн захиалгат сургалтад 3 байгууллагын 50 албан хаагчийг тус тус хамруулж, суралцах явцад хяналт тавин ажиллаж байна. Мөн Баг/хорооны засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны зорилтот танхимын сургалтад 29 багийн Засаг дарга нарыг 100 хувь хамруулсан. Монгол Улсын хөгжлийн бодлого хэрэгжилт - Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтад 3 албан хаагчийг хамруулсан. Энэ сургалтаар хөгжлийн бодлого, төлөвлөлт ба байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төвөллөгөөг уялдуулан төлөвлөх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн мэдлэг, ур чадвар эзэмшлэлж, эзэмшсэн сургалтын агуулгын хүрээнд 37 байгууллагын 58 албан хаагчдад танхимын 2 өдрийн сургалт зохион байгуулсан. Төрийн албаны зөвлөл, “Мерит” төслөөс хамтран “ Хувь хүний хөгжил”-ийн чиглэлээр 7 хоног бүрийн Пүрэв гаригт цахим сургалтад Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, Захиргаа, удирдлагын газар (хэлтэс)-ын дарга, агентлагуудын хүний нөөцийн ажилтан, аймаг, сумдын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга нарыг нийт давхардсан тоогоор 1952 албан хаагч хамруулсан. 2024.01.01.-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
9	Арга хэмжээ 3.3 Төрийн захиргааны албан хаагчдын тангараг өргөх арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан байдал	Гүйцэтгэлээр	Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, Соёл урлагийн газар, Хотын Захирагчийн алба, Эрүүл мэндийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Жаргалант сум ЗДТГ, Нийгмийн даатгалын газар, Орон нутгийн өмчийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Татварын газар нийт 12 төрийн захиргааны байгууллагын 25 төрийн албан хаагч тангараг өргөх арга хэмжээг зохион байгуулагдлаа. 2024.01.01.-2024.12.31 Хэрэгжилт хувь: 100%

10	Арга хэмжээ 3.4 Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах	Хуралдааны тоо	Гүйцэтгэлээр	Тайланд хугацаанд төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах асуудлаарх нутгийн захиргааны байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны санал, танилцуулгыг төрийн захиргааны 22 байгууллагаас хүлээн авч судлан аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар 6 удаа хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүлээсэн үүргээ “Хангалттай сайн” биелүүлсэн нийт ахлах түшмэл 14, дэс түшмэл 85, туслах түшмэл 38 бүгд 137 төрийн жинхэнэ албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох болон ахиулах ажлыг зохион байгуулсан. 2024.01.01.-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
11	Арга хэмжээ 3.5.Төрийн албан хаагчийг холбогдох журамд заасны дагуу шагнаж урамшуулах саналыг салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах	Хуралдааны тоо	Гүйцэтгэлээр	Салбар зөвлөлд 1 албан хаагчийг холбогдох журамд заасны дагуу шагнаж урамшуулах санал ирүүлсэн боловч шагналын материал хүлээн авах хугацаа хэтэрсэн тул ТА3 хүлээн аваагүй болно. 2024.01.01.-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
ДӨРӨВ. “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧ, УГ АЛБАНД НЭР ДЭВШИГЧИЙН ХООРОНД ТӨРИЙН АЛБАТАЙ ХОЛБОГДСОН АСУУДЛААР ГАРСАН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ САХИУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
12	Арга хэмжээ 4.1. Маргаан хянан шалгах комиссын үүрэг даалгаврын дагуу асуудлыг шалгах, холбогдох баримт материалыг бүрдүүлэх	Бүрдүүлсэн материалын тоо	Гүйцэтгэлээр	Маргаан хянан шалгах комиссын үүрэг даалгаврын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн даргын, Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн захиарлын сонгон шалгаруулалтай холбоотой холбогдох баримт материалыг бүрдүүлэх, тайлбар, материал мөн Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнхцэцэгтэй холбоотой асуудлыг шалгах, холбогдох баримт материалыг бүрдүүлэн хугацаанд нь хүргүүлсэн. 2024.01.01.-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%

13	Арга хэмжээ.4.2 .Төрийн захиргааны албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн асуудлаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх.	Зөвлөгөө үзүүлсэн тоо	Гүйцэтгэлээр	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2-т заасны дагуу “Ёс зүйн дэд хороо” байгуулах зөвлөмжийг өгч арга зүйн удирдлагаар ханган 65 төрийн байгууллагад “Ёс зүйн дэд хороо” шинэчлэн байгуулан дэд хороодод 267 албан хаагчид томилогдон ажиллаж байна. Төрийн захиргааны албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн асуудлаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэхээр Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд орон нутагт ажиллаж байгаа бөгөөд Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгсөөр ахлуулсан ажлын хэсэг Ёс зүйн дэд хороодын дарга, гишүүдэд гишүүдийн төлөөлөлтэй уулзалт хийж, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад 66 байгууллагын 100 төрийн албан хаагч оролцсон. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудаас “Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн. 2024.01.01.-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
ТАВ. “СУРГАЛТ СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
14	Арга хэмжээ 5.1. Төрийн албан хаагчдын сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх, хөтөлбөр, удирдамжийн дагуу сургалт зохион байгуулах	Сургалтын тоо	Гүйцэтгэлээр	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд орон нутагт ажиллаж байгаа бөгөөд Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгсөөр ахлуулсан Ажлын хэсэг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг хийж, Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналтын талаар мэдээлэл өгч сургалт зохион байгуулсан. Сургалтад танхимаар 67 байгууллагын 183 төрийн албан хаагч, цахимаар 100 цэгээс 1170, нийт 1353 албан хаагч оролцсон. . Төрийн албан хаагчдын сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаа хийж, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх орон нутгийн захиалгат сургалтад 3 байгууллагын 50 албан хаагчийг тус тус хамруулж, суралцах явцад хяналт тавин ажиллаж байна.

			Мөн Баг/хорооны засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны зорилтот танхимын сургалтад 29 багийн Засаг дарга нарыг хамруулсан. Төрийн албаны зөвлөл, “Мерит” төслөөс хамтран “Хувь хүний хөгжил”-ийн чиглэлээр 7 хоног бүрийн Пүрэв гаригт цахим сургалтад Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, Захиргаа, удирдлагын газар (хэлтэс)-ын дарга, агентлагуудын хүний нөөцийн ажилтан, аймаг, сумдын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга нарыг нийт давхардсан тоогоор 1952 албан хаагч хамруулсан. 2024.01.01.-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
15	Арга хэмжээ 5.2 Удирдлагын академитай хамтран төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх болон зайн сургалтуудад хамруулах	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Гүйцэтгэлээр Удирдлагын академийн орон нутгийн менежерийн үүрэг гүйцэтгэж, 2024 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран “Баг/хорооны засаг дарга нарыг чадавхжуулах нь” богино хугацааны сургалтад Сургагч багш бэлтгэх сургалтад 2 байгууллагын 3, нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 5 байгууллагын 5, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 12 байгууллагын 12, дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 16 байгууллагын 17 төрийн албан хаагч, цаашид ажиллах ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 8 байгууллагын 11 төрийн албан хаагч, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 1 байгууллагын 1 албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх орон нутгийн захиалгат сургалтад 3 байгууллагын 50 албан хаагчийг тус тус хамруулж, суралцах явцад хяналт тавин ажиллаж байна. Мөн Баг/хорооны засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны зорилтот танхимын сургалтад 29 багийн Засаг дарга нарыг 100 хувь хамруулсан. Монгол Улсын хөгжлийн бодлого хэрэгжилт - Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтад Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга А.Өнөржаргал, Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Баасансүрэн, Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Ууганцэцэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Орон нутгийн бодлого, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн М.Пүрэвмаа нар

				2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдөөс 3 хоног Удирдлагын академи дээр танхимын сургалтанд хамрагдсан. Энэ сургалтаар хөгжлийн бодлого, төлөвлөлт ба байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төвөлгөөг уялдуулан төлөвлөх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн мэдлэг, ур чадвар эзэмшлэлж, эзэмшсэн сургалтын агуулгын хүрээнд 37 байгууллагын 58 албан хаагчдад танхимын 2 өдрийн сургалт зохион байгуулсан. 2024.01.01.-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
16	Арга хэмжээ 5.3 Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн хэвийн тасралтгүй, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд зөвлөгөө өгөх	Зөвлөгөө үзүүлсэн тоо	Гүйцэтгэлээр	Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн хэвийн тасралтгүй, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийг тогтоосон хугацаанд оруулах, тайлагнах талаар төрийн захиргааны байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган, аймгийн Засаг даргын дэргэдэх төрийн захиргааны байгууллагуудад нэгбүрчлэн ажлын байран дээр нь очиж Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийг хөтлөж байгаа байдалд хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд орон нутагт ажилласан бөгөөд Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгсөөр ахлуулсан ажлын хэсэг Орхон аймагт ажиллахад төрийн байгууллагуудын “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн баяжуулалт бүрэн, сайн хийгдсэн гэж үнэлэгдсэн. 2024.01.01.-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
17	Арга хэмжээ 5.4 Тоо бүртгэлийн санд нэмэлт өөрчлөлт оруулах, тоо бүртгэл хөтлөх талаар арга зүйн удирдлагаар хангах	Арга зүйн дэмжлэгийн тоо	Гүйцэтгэлээр	Нутгийн захиргааны байгууллагуудад төрийн албан хаагчийн тоо бүртгэлийн санд хүний нөөцийн системээр тайлан мэдээг гаргах, тухай бүр мэдээлэл оруулж баяжуулж байхтай холбоотой арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж, 2023 оны тайлан мэдээг 95 байгууллагуудаар гаргуулан хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган тогтоосон хугацаанд тайланг гаргаж Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Тоо бүртгэлийн санд нэмэлт өөрчлөлт оруулах, тоо бүртгэл хөтлөх талаар арга зүйн удирдлагаар хангаж 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 27 түр чөлөөлөгдсөн нөөц бүртгэлтэй байна. Үүнээс Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгож төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэний нөөц-3, Төрийн албаны тухай хуулийн 46.1.1 –д

заасны дагуу 11 /эрүүл мэнд/, 46.1.2-д заасны дагуу 10/ 6 дээш сар сурах/, байгууллага нь татан буугдсан -3 иргэн бүртгэлтэй байна. 2024.01.01.-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%

ЗУРГАА. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

18	Арга хэмжээ № 6.1. Салбар зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд салбар зөвлөлийн дарга, гишүүдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах	Хэрэгжилт (хувь)	70	Аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл 2024 оныг "Төрийн байгууллагуудын бүтээмж, чадавхийг сайжруулахад мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хуулиа дээдлэн иргэдээ эрхэмлэсэн төрийн албаны төлөө" зорилтыг дэвшүүлэн ажилласан. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлан хэрэгжилтийг хангуулан ажилласан. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 9 бүлэг 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 55 ажил үйлчилгээг зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан баталуулж хэрэгжилтийг хангуулан ажилласан. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
19	Арга хэмжээ №6.2. Салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэл хангах, хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	Хэрэгжилт (хувь)	70	Аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдааныг 16 удаа зохион байгуулан 2023 оны салбар зөвлөлийн тайлан, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай, Ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах салбар комисс байгуулах тухай, Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтуудын нэгдсэн дүн, Төрийн албаны Ерөнхий шалгалтуудын нэгдсэн дүн, Төрийн албаны тусгай шалгалтад тэнцсэн иргэдийг Нэр дэвшүүлэх тухай зэрэг 40 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн ба хуралдааны шийдвэртэй холбоотой Салбар зөвлөлийн 95 тогтоолыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа. Хуралдааны тэмдэглэлийг тухай бүрт нь хөтлөн албажуулж байна. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
20	Арга хэмжээ 6.4. Салбар зөвлөлийн архив, албан хэрэг хөтөлж,	Архивт шилжүүлсэн баримтын тоо	7	Салбар зөвлөлийн архив, албан хэрэг хөтлөлт эрхлэн 2023 оны архивын материалыг Засаг даргын Тамгын газрын архив хүлээлгэн өгч төрийн болон албаны нууцын асуудлыг эрхлэх, тайлан мэдээг хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан.

	хөтлөгдөж дууссан бичиг хэргийг байгууллагын архивт шилжүүлэх			2024.01.01-2024.12.31	Биелэлтийн хувь: 100%
21	Арга хэмжээ 6.5. Төрийн байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон хугацаатай албан бичгийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариу өгөх	Хугацаа	7-14 хоног	Төрийн байгууллага, иргэдээс ирүүлсэн 10 өргөдөл, гомдол болон хугацаатай 180 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэж, холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн.	2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
22	Арга хэмжээ 6.6. Салбар зөвлөлийн төрийн болон албаны нууцын асуудлыг эрхлэх, тайлан мэдээг хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэх	Хугацаа	Гүйцэтгэлээр	Салбар зөвлөлийн төрийн болон албаны нууцын асуудлыг эрхлэх, тайлан мэдээг хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн.	2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4
НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ			
23	Арга хэмжээ 7.1 "Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр"-ийн хэрэгжүүлэх Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах	Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Хөтөлбөр батлах тухай" 13/05 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөрийг, аймгийн Засаг даргын 2023 оны А/811 дүгээр захирамжаар тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах Ажлын хэсгийн ажиллах журмыг баталсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх Ажлын хэсэгт Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь Салбар зөвлөлийн 3 гишүүн ажиллаж байна. "Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр"-ийг 2024 онд хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 500.0 сая төгрөг шийдвэрлэсэн бөгөөд тус Ажлын хэсгийн 7 удаагийн хурлыг зохион байгуулсан. Ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу "Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр"-ийг 2024 онд хэрэгжүүлэхэд төлөвлөгөөг аймгийн

10

			Засаг даргаар баталуулан төрийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. 2024 онд 16 арга хэмжээг төлөвлөн ажилласан бөгөөд тухайн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, 33-21 жил ажилласан 11 байгууллагын 16 төрийн албан хаагчдад 111.9 сая , Удирдлагын академитай хамтран анх төрийн албанд орсон албан хаагчдад чиглүүлэх богино хугацааны сургалтад 3 байгууллагын 50 албан хаагч, " Хөгжлийн бодлого, хэрэгжилт- үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сэдэвт сургалтад 5.0 сая төгрөгний санхүүжилтээр 34 байгууллагын 68 албан хаагчийг хамруулсан., тогтвор суурьшилтай, ажлын амжилт гаргасан 13 байгууллагын 14 төрийн албан хаагчийг гадаад улсад туршлага судлуулах дэмжлэгт 89.9 сая төгрөг, салбарын хэмжээний тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой эрдэм шинжилгээний бүтээл туурвисан, идэвх санаачилга гарган ажлын амжилт гаргасан, мэдлэг мэргэжлээ тогтмол дээшлүүлж байгаа болон бодит үр дүнд хүрсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн, олон нийтийг зэрэг өөрчлөлт, сайн үр дүн гаргасан дэмжлэг 5 албан хаагчдад, магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр болон сайн дураараа цус, эс, эд, эрхтнээ бусдад үнэ төлбөргүй өгч донорын үүрэг гүйцэтгэсэн дэмжлэг 2 албан хаагчдад, өрхийн орлого буурч, нэг гишүүнд ногдох хэмжээ нь хүн амын амьжиргааны доод түвшинд хүрэхгүй болсон тохиолдолд гэр бүлийг нь дэмжих дэмжлэг 4 албан хаагчдад 8.0 сая төгрөг, эмчилгээний зардалд 4 албан хаагчдад 24.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмж, тавилгаар хангах, төрийн албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт оруулах, дархлааг дэмжин амин дэм олгох зэрэг ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол гарсантай холбогдуулан төрийн захиргааны албанд 5 жил тасралтгүй ажилласан төрийн албан хаагчдад урамшуулал олгох ажлыг зохион байгууллаа. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
24	Арга хэмжээ 7.2 Удирдлагын академийн орон нутгийн менежерийн үүрэг гүйцэтгэх, хамтран сургалт зохион байгуулах	Салбар зөвлөлийн дарга	Удирдлагын академийн орон нутгийн менежерийн үүрэг гүйцэтгэж, 2024 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран "Баг/хорооны засаг дарга нарыг чадавхжуулах нь" богино хугацааны сургалтад Сургагч багш бэлтгэх сургалтад 2 байгууллагын 3, нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх

22

			томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 5 байгууллагын 5, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 12 байгууллагын 12, дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 16 байгууллагын 17 төрийн албан хаагч, цаашид ажиллах ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 8 байгууллагын 11 төрийн албан хаагч, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 1 байгууллагын 1 албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх орон нутгийн захиалгат сургалтад 3 байгууллагын 50 албан хаагчийг тус тус хамруулж, суралцах явцад хяналт тавин ажиллаж байна. Мөн Баг/хорооны засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны зорилтот танхимын сургалтад 29 багийн Засаг дарга нарыг 100 хувь хамруулсан. Монгол Улсын хөгжлийн бодлого хэрэгжилт - Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтад Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга А.Өнөржаргал, Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Баасансүрэн, Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Ууганцэцэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Орон нутгийн бодлого, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн М.Пүрэвмаа нар 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдөөс 3 хоног Удирдлагын академи дээр танхимын сургалтанд хамрагдсан. Энэ сургалтаар хөгжлийн бодлого, төлөвлөлт ба байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төвөллөгөөг уялдуулан төлөвлөх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн мэдлэг, ур чадвар эзэмшлэлж, эзэмшсэн сургалтын агуулгын хүрээнд сургалт зохион байгуулах мэдлэг бүхий сургагч багш бэлтгэх зорилготой. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
25	Арга хэмжээ 7.3 Аймгийн Засаг дарга болон Тамгын газрын даргын шийдвэрээр Ажлын хэсэгт ажиллах	Аймгийн Засаг дарга	Аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оны захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт–шинжилгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх Ажлын хэсэгт ажиллан Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан. Тамгын газрын даргын шийдвэрээр Хойд бүсийн форум хэлэлцүүлэг зохион байгуулах Ажлын хэсэг, Төрийн одон медаль гардуулах Ажлын хэсэгт тус тус ажилласан.

			2024.01.01-2024.12.30	Биелэлтийн хувь: 100%
--	--	--	-----------------------	-----------------------

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	
		Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт
1	2	3	4
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД			
26	Хууль эрх зүйн эчнээ ангид суралцаж төгсөх	Тухайн жилийн хичээлдээ бүрэн сууж шалгалтаа өгсөн байна.	2024 оны хичээлдээ цахимаар суралцан, шалгалтууддаа бүрэн өгсөн. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%
27	Удирдлагын Академийн сургалтын хөтөлбөр"-т хамрагдах	Богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдсан байна.	Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуульд "Төрийн албан хаагчийн сургалтын зохион байгуулалт 16 цагийн танхимын сургалтанд хамрагдан гэрчилгээ авсан. Солонгос Улсад Нутгийн удирдлагын хөгжлийн институтэд сургагч багш, төрийн албан хаагчийг чадавхижуулах сургалтад танхимын сургалтанд хамрагдан гэрчилгээ авсан. Монгол Улсын хөгжлийн бодлого хэрэгжилт - Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтад 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдөөс 3 хоног Удирдлагын академи дээр танхимын сургалтанд хамрагдсан. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь:100%
28	Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг судлах	Шинээр гарсан хууль тогтоомжийг судалсан байна.	Төрийн албаны зөвлөл, "Мерит" төслөөс хамтран "Хувь хүний хөгжил"-ийн чиглэлээр 7 хоног бүрийн Пүрэв гаригт цахим сургалтыг 29 удаа цахимаар зохион байгуулагдан хамрагдсан. 2024.01.01-2024.12.31 Биелэлтийн хувь: 100%

42

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРИЙН
ЗӨВЛӨЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН
БИЧГИЙН ДАРГА
(Албан тушаал)

АЛБАНЫ
САЛБАР
НАРИЙН

..... / А.ӨНӨРЖАРГАЛ / 2014.12.05

(Нэр, гарын үсэг)

(Огноо)